



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

「 Оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай 」

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 60 дугаар зүйлийн 60.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн оноосон нэрийг “Амар даатгал” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Э.Мөнгөнзул/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН